

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАРЫН УНГАР УЛСАД
ХИЙСЭН АЙЛЧЛАЛЫН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ОРЖ АЖИЛЛАСАН
ТАЙЛАН

2024 оны 03 дугаар сарын 20

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын 2024 оны 03 дугаар сарын 06-12-ны өдрүүдэд Унгар Улсад хийх айлчлалын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, Иргэний нисэхийн ерөнхий газрыг төлөөлөн оролцлоо.

Уг уулзалтад Унгар Улсын Зам тээврийн сайд Janos Lazar, Нийгмийн хамгаалал, удирдлагын яамны төрийн нарийн бичгийн дарга Dr. Tunde Juhasz, Зам тээврийн яамны төрийн нарийн бичгийн дарга Balint Nagy, Агаарын тээврийн удирдах газрын төрийн нарийн бичгийн дарга Dr. Janos Kerekgyarto тэргүүлэгчтэй төлөөлөгчид оролцлоо.

Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайд “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-г 2024 оны 3 дугаар сарын 7-нд Будапешт хотноо гарын үсэг зурснаар Монгол Улсын Иргэний нисэхийн салбарт түүхэн үйл явц болсон. Хэлэлцээрт гарын үсэг зурсны дараа Унгар Улсын Гадаад харилцааны яамны төрийн нарийн бичгийн дарга Пэтер Штарайтай уулзаж, дараах чиглэлээр санал солилцов. Үүнд:

1. Хоёр орны уламжлалт найрсаг харилцааг худалдаа, эдийн засаг, бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэхийн чухлыг тэмдэглэж, Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр чухал ач холбогдолтойд талууд санал нэгдэв.

2. Энэхүү хэлэлцээрийг байгуулснаар хоёр орны хооронд шууд нислэг гүйцэтгэх эрх зүйн боломж бүрдэхээс гадна цаашид Европын орнууд руу шинээр нээх нислэгийн завсрын цэг болгон ашиглах боломжтой ба Европын Холбооны улсууд руу зөвхөн Франкфурт, Истанбул чиглэлийн нислэгээр дамжин явдаг манай улсаас зорчих зорчигчдын хувьд аялалын хугацааг богиносгож, улмаар нислэгийн зардлыг бууруулах давуу тал бий болж буйг онцлон тэмдэглэв.

3. Нислэгийн цэг, тоо давтамж нэмэгдэхийн хэрээр хоёр улсын худалдааны эргэлт нэмэгдэж, аялал жуулчлалын салбар өргөжих боломжтойгоос гадна хоёр улсын иргэд, бизнес аялагчид, жуулчид бага хугацаанд, тав тухтай, хямд зардлаар, нисэх боломжтойд талууд санал нэгдэв.

Зам, тээврийн хөгжлийн сайдыг салбарын болон бусад холбогдох мэдээллээр хангах, бусад шаардлагатай дэмжлэгийг үзүүлж ажилласан.

Унгар Улсын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын албаны төлөөлөгчидтэй 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр албан уулзалт хийж цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцож, Унгарын Иргэний нисэхийн салбарын бүтэц зохион байгуулалт, хэрхэн санхүүжилт хийдэг, мэргэжлийн сургалт, дадлагыг хэрхэн зохион байгуулдаг, Хүний нөөцийн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар, дадлага туршлагатай байцаагч хэрхэн бэлтгэдэг болон менежментийн системийг хэрэгжүүлсэн талаар туршлага судалж санал солилцож, доорх

асуудлуудыг хэрхэн шийдвэрлэсэн талаар танилцлаа.

- Чадварлаг мэргэшсэн боловсон хүчнийг хэрхэн үр ашигтайгаар бэлтгэх.
- Хяналтын байцаагчийн сургалт, цалин, урамшуулал, тогтвор суурьшилтай ажиллах боломжийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн талаар.
- Унгарын дотоодын Агаарын тээвэрлэгчдийн талаарх мэдээлэл.
- Хяналт шалгалтыг хэрхэн хэрэгжүүлдэг талаарх мэдээлэл, "Ramp Inspection Programme"-ийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар.
- Аюулгүй ажиллагааны хяналт, осол зөрчлийн талаарх мэдээлэл.

Дүгнэхэд Унгар Улсад хийсэн айлчлал нь "Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-г гарын үсэг зурснаар цаашид хоёр улсын хоорондын шууд нислэг үйлдэх эхлэх амжилттай тавигдаж, хоёр орны тээврийн салбарт баримталж буй бодлого, үйл ажиллагааны талаар харилцан мэдээлэл солилцож, тээврийн салбарын хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашид авах зарим арга хэмжээний тапаар тохиролцов.

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ХЭЛТСИЙН ДАРГА



/Г.БАТБАЯР/

ТАЙЛАН ГАРГАСАН:

НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД НИСЭХИЙН
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТЫН
УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ



/П.ГАНБОЛД/